

# Сургаал, зарчмуудыг тодорхойлж сурах

Сайн мэдээний зарим сургаал, зарчмыг судруудад тодорхой дурдсан байдаг. Зарим сургаал, зарчмыг үйл явдалд суулгаж өгсөн байж болох бөгөөд гагцхүү ном, бүлгийг бүтнээр нь судалснаар юм уу ганц шүлэг судалснаар олж мэддэг. Та судраас судлахдаа сайн мэдээний үнэнүүдийг тодорхойлоход туслах дараах чухал алхмуудыг дагах дасгал хийж болно. Үүнд:

1. Удаан, анхааралтай унш.
2. Тодорхой илэрхийлсэн үнэнүүдийг эрж хай. Тэдгээрийн зохиогч заримдаа “бид харлаа,” “тиймийн тул,” “иймийн тул” эсвэл “болгоогтун” гэх мэт үгсийг ашиглан илэрхийлдэг.
3. Далд үнэнүүдийг эрж хай. Та нар дараахтай адил асуултуудыг өөртөө тавих замаар тэдгээр үнэнийг олж болно.
  - a. Энд чухал санаа, үг, хэллэг; ялангуяа Тэнгэрлэг Эцэг, Түүний төлөвлөгөөг эсвэл Есүс Христ, Түүний сайн мэдээг илүү сайн мэдэхэд туслах санаа, үг хэллэг байна уу?
  - b. Энэ түүхэд учир шалтгаан, үр дагаврын ямар холбоо хамаарал байна вэ?
  - c. Энэ түүхийн сургамж эсвэл гол санаа юу вэ?
  - d. Яагаад бичээч эдгээр үйл явдал, судрын хэсгийг оруулсан гэж бодож байна вэ?
4. Олсон зүйлээ өөрийн үгээр бичээд, энэ тухай заасан үгсийг судар дээрээ тэмдэглэ.
5. Уг үнэн яагаад чиний хувьд чухал болохыг тунгаан бод. Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд ийн заасан.



Судрын үг бүрийг, эрдэнэс бүрийг нарийн шинжиж, . . . тунгаан бод. . . . Үүнийг гэрэлд барин, эргүүлж тойруулан үзэж, юу тусаж, юу ойж байгааг хар. . . . Ингэж нягтлан судалснаараа талбайд нуусан эрдэнэсийг, агуу үнэт сувд буюу ямар ч зүйлээс үнэтэй сувдыг . . . нээж олж болох юм. (“Students Need Teachers to Guide Them” [address to Church Educational System religious educators, June 20, 1992], 4)